

Австрийн тэтгэлгийг 23 докторант авлаа

Р.ОЮУНЦЭЦЭГ

Австри улсын Засгийн газраас Монголд суралцаж буй 23 докторантад тэтгэлэг олгосныг БСШУ-ы сайд Ө.Энхтүвшин өчигдөр гардууллаа.

Энэхүү тэтгэлэг нь 2002 оноос манай улсад хэрэгжих болсон Европ, Ази номхон далайн орнуудын их, дээд сургуулиудын "UNINET" сүлжээний төслийн хүрээнд хийж буй ажил бөгөөд энэ хугацаанд ШУТИС, ШУА, МУИС, ЭМШУИС-ийн нийт 50 оюутанд 78000 еврогийн тэтгэлэг олгожээ.

Энэ жилийн хувьд тус сургуулиудаас 18 доктор Монголдоо судалгаа шинжилгээний ажил хийх 25500 еврогийн, таван оюутан Австрийн их, дээд сургуульд докторын дараах сургалтад нэг жил хамрагдах 39300 еврогийн тэтгэлэг авч байгаа аж. Эдгээр оюутнуудад докторын зэрэг хамгаалаад өөрийн орны их, дээд сургууль, шинжлэх ухааны байгууллагад хоёроос доошгүй жил ажилласан, англи, герман хэлний аль нэгийг мэргэжлийнхээ түвшинд хэрэглэх чадвартай болон хэрэв Австрид докторын дараах сургалтад хамрагдах бол тухайн улсын ямар нэг профессортой зайлшгүй харилцаатай байх зэрэг шаардлага тавьдаг байна.

БСШУ-ы Ө.Энхтүвшин докторант, оюутнуудад

баяр хүргээд "Өмнөх жилүүдийн туршлагаас үзэхэд нийгмийн захиалгыг авч үзэлгүйгээр баахан судалгаа хийж, маш их хөрөнгө, хөдөлмөр зарцуулаад эргээд уг судалгаа нь амьдрал, үйлдвэрлэлд нэвтэрч, хэрэгжих боломжгүй болох явдал байсан. Тийм учраас Та бүхэн суурь судалгаагаа шинжлэх ухаан үйлдвэрлэлд, хавсралт судалгаагаа аль болох амьдралтай ойртуулж бодитой хийхийг анхаараарай. Зөвхөн Засгийн газар бус олон нийт, орон нутаг, хувийн хэвшлийн байгууллагуудын захиалгыг авч болно. Хэрэв захиалга авсан бол тэр ажлаа заавал хийх ёстой.

Бид цаашид их, дээд сургуулийн тоо, чанарт болон нийгэмд хэрэгцээтэй мэргэжлийн оюутны тоог нэмэгдүүлж, хэрэгцээнээс хальж буйг нь багасгахад анхаарна. Өнөөдөр манайд байгалийн ухаан, эрүүл мэнд, инженер, технологийн боловсон хүчин хамгийн их хэрэгтэй байгаа. Та бүхнээс их зүйл хүлээж байна" хэмээн хэлсэн юм.

Харин төслийн зохион байгуулагчид эдгээр залуусыг Монгол, Австрийн харилцааны гүүр болно хэмээн үзэж байгаагаас гадна цаашид тэтгэлэгт хамрагдсан хүмүүсийн холбоо байгуулах бөгөөд тэд эргээд хоёр орныг холбоно хэмээн үзэж байгаа аж.